



Татварын талаарх илэн далангүй яриа



Татварын шинэтгэл, түүнийг хаанаас эхлэх вэ?

Монгол Улсын татварын бодлого монголын эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болж чадаж байна уу?

Татварын тогтолцоог өөрчилж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг тэгш, шударга зарчмаар дэмжих байр суурийг Засгийн газар барьж байна. Нэмэлт хөрөнгө оруулалтын үр дүнд ажлын байр бий болж улмаар ядуурал буурах юм. Уг ажлын байрууд бодитоор бий болсноор татварын бааз суурь нь өөрөө өргөжих талтай. Татварын баазыг өргөтгөснөөр татварын хувь, хэмжээ бууруулах боломж бүрддэг.

Татварын суурь * Татварын хувь = Төсөвт орох татварын орлого

Төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэхийн тулд төрд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө шаардлагатай болдог. Одоогоор манай улсын хувьд татварын бааз сул байгаа бөгөөд татвар төлөгчдийг өндөр хувиар татвар ногдуулах хандлага байна.

Засгийн газраас ямар өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байна вэ?

Хамгийн гол сэдэв нь аж ахуйн нэгжид үзүүлж буй татварын ачаалал болж байна. Үүнд орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар голлон хамаарна. Уг хоёр татвараас улсын төсвийн орлогын тал хувь бүрдэхээс гадна эдгээр нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас ихээхэн хамаарч байдаг. Бизнесийн өсөлтийг дэмжих зорилгоор Засгийн газраас Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар төлөвлөөд байна:

- Татварын 15, 30 хувийн босгыг өсгөх: Одоо мөрдөж буй 100 сая төгрөгийн босго нь аж ахуйн нэгжийн өсөлт, хөрөнгийн төвлөрөлт, үр ашигт ажиллагаа, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж улмаар охин компаниуд бий болгоход хүргэж байна. Аж ахуйн нэгжийн 15 хувиар татвар төлөх орлогын хэмжээг өсгөснөөр бизнесийн өсөлтийг дэмжих таатай орчин бүрдэх юм.
- Аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг дэмжих: Үүнийг хурдасгасан элэгдэл байгуулж хөрөнгө оруулалтаа түргэн нөхөх эсвэл, татварын хөнгөлөлт үзүүлж хөрөнгө оруулалтын зарим хэсгийг буцааж олгох замаар хийж болно.
- Хасагдах зардлын төрлийг нэмэх: Одоо мөрдөж буй хууль нь бизнесийн үйл ажиллагаанд зайлшгүй гарах зардлыг хязгаарлаж байна. Жишээ нь: Зар сурталчилгаа болон сургалтын зардлыг гүйцэтгэлээр нь тооцдог болох. Заавал болон сайн дурын даатгалын төлбөрийг хасагдах зардалд оруулах.
- Татварын хөнгөлөлт, амралтыг хасах: Хуулийн олон заалтууд тодорхой нэг хөрөнгө оруулагч, үйлдвэрлэлийг орлогын албан татвараас чөлөөлж байна. Хэдийгээр энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой гэсэн ойлголт урьд нь давамгайлж байсан боловч татварын хөнгөлөлт, амралт нь дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Дээрх заалтууд нь хуульд оруулахаар төлөвлөж буй томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийн нэгээхэн хэсэг болно. Гэхдээ Засгийн газраас татварын бодлогын чинэтгэл хийхтэй зэрэгцүүлэн төсвийн орлого, зарлага болон эдийн засгийн нөлөөллийг сайтар анхааран үзэх шаардлагатай. Мөн монголын татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өрсөлдөх чадвараа сайжруулах нь нэн чухал юм.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд мөн өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Үүнийг дараа долоо хоногийн дугаартаа нийтлэх болно.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн зургаа дугаар хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг “Нээлттэй засаг” вэб сайт (www.opengovernment.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.